



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 601

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 13 нэрийн, нийт 4,760,961.91 (дөрвөн сая долоон зуун жаран мянга есөн зуун жаран нэгэн төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 4,760,961.91 (дөрвөн сая долоон зуун жаран мянга есөн зуун жаран нэгэн төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Алимаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 1 дугаар сарын 19-ны өдрийн
60/1 дугаар тогтоолын хавсралт

ДОРНОД АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон огноо	Нэгж балансын үнэ /төгрөг/	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Цашид ашиглах хугацаа /жил/	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ /төгрөг/	Шинэчлэн тогтоох нийт үнэ /төгрөг/
1	Номын шүүгээ	2	12/1/2013	358,390.00	716,780.00	3	358,390.00	716,780.00
2	Уулзалтын ширээ	1	12/30/2008	205,000.00	205,000.00	3	205,000.00	205,000.00
3	Албаны ширээ	3	11/10/2008	231,000.00	693,000.00	3	231,000.00	693,000.00
4	Албаны ширээ	2	11/10/2008	265,000.00	530,000.00	3	265,000.00	530,000.00
5	Конторын тавилга	1	1/1/2004	1026900	1,026,900.00	3	1026900	1,026,900.00
6	Бичгийн ширээ	1	10/31/2014	112,295.75	112,295.75	3	112,295.75	112,295.75
7	Компьютерийн ширээ	1	1/1/2004	162,185.00	162,185.00	3	162,185.00	162,185.00
8	Модон хаалгатай бичиг баримтын шүүгээ	1	10/31/2014	117,308.95	117,308.95	3	117,308.95	117,308.95
9	Шилэн хаалгатай бичиг баримтын шүүгээ	1	10/31/2014	183,483.23	183,483.23	3	183,483.23	183,483.23
10	Шургуулгатай шүүгээ	1	12/1/2013	123,358.00	123,358.00	3	123,358.00	123,358.00
11	Бичгийн ширээ	2	10/31/2014	154,406.66	308,813.32	3	154,406.66	308,813.32
12	Ажилтаны ширээ	4	12/30/2008	122,900.00	491,600.00	3	122,900.00	491,600.00
13	Зүүж бэхэлдэг шүүгээ	1	10/31/2014	90,237.66	90,237.66	3	90,237.66	90,237.66
		21		3,152,465.25	4,760,961.91		3,152,465.25	4,760,961.91
	Нийт дүн				(Дөрвөн сая долоон зуун жаран мянга есөн зуун жаран нэгэн төгрөг ерэн нэгэн мөнгө)			(Дөрвөн сая долоон зуун жаран мянга есөн зуун жаран нэгэн төгрөг ерэн нэгэн мөнгө)